

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн талбайн хүсэлтэд дараах хэлбэрээр санал өгнө:”

“12.2.1.Энэ хуулийн 12.2-д заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 60 хоногийн дотор төрийн захиргааны төв байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.”

“12.2.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга зөвхөн хуульд заасан үндэслэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгч болно.”

2/ 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалт:

“энэ хуулийн 5.3-5.5-д заасан орд ашиглах гэрээний загварыг батлах”

3/ 10 дугаар зүйлийн 10.1.19 дэх заалт:

“Энэ хуулийн 11.1.25-д заасны дагуу тодорхойлж ирүүлсэн талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой эсэх талаар аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авч, нэгтгэх ажлыг зохион байгуулах”

4/ 10 дугаар зүйлийн 10.1.20 дахь заалт:

“хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн бүртгэлийг хүлээн авах журам батлах”

5/ 10 дугаар зүйлийн 10.1.21 дэх заалт:

“10.1.21.Ил, далд уурхай, баяжуулах үйлдвэр болон геологи, хайгуулын судалгааны ажилд баримтлах аюулгүй байдлын дүрмийг тус тус батлах”

6/ 10 дугаар зүйлийн 10.1.22 дахь заалт:

“Ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журмыг батлах”

7/ 10 дугаар зүйлийн 10.1.23 дахь заалт:

“энэ хуулийн 9.1.14-т заасан орд ашиглах гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах.”

8/ 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалт:

“Энэ хуулийн 9.1.11-д заасан талбайд хамаарагдсан байх.”

9/ 19 дүгээр зүйлийн 19.13 дахь заалт:

“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг эрх бүхий байгууллагаас шийдвэрлэсэн бөгөөд мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т заасан талбайтай давхцаагүй бол төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг олгож, тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлд бүртгэнэ”

10/ 27 дугаар зүйлийн 27.1.14 дэх заалт:

“Олборлолтын үйл ажиллагааны явцад бий болсон овоолго, хаягдлаас ашигт малтмал олборлох, ялган авах эрхийг бусад хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр олгох”

11/ 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг:

“Ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь энэхүү хуулийн 10.1.21 дэх заалтаар батлагдсан аюулгүй байдлын дүрмүүдийг мөрдөж ажиллана.”

12/ 48 дугаар зүйлийн 48.6.4 дэх заалт:

“Ашиглалтын үйл ажиллагааны тухайн жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23 дахь заалтын “газар...” гэсний дараа “энэ хуулийн 4.1.23-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэх...” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.3 дахь заалтын “хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон...” гэсний дараа “, сонгон шалгаруулалтын...” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.4, 19.2.3 дахь заалтын “тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон...” гэсний дараа “, сонгон шалгаруулалтын...” гэж, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт “эзэмшигч...” гэсний дараа “болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч...” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 7.1, 17.2-т заасан шаардлага хангасан бөгөөд хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгоно.” гэснийг “Энэ хуулийн 7.1, 17.2-т заасан шаардлага хангасан, хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох бөгөөд өргөдлийн бүртгэлийг цахим сүлжээгээр болон бусад хэлбэрээр хүлээн авч болно.” гэж, 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасан саналыг дэмжсэн хариу өгсөн бол” гэснийг “Энэ хуулийн 12.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авсан бөгөөд мөн хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийн “ордыг эзэмшигчийн” гэснийг “ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “бүртгэнэ” гэснийг “ажлын 10 хоногт багтаан бүртгэж, хариу мэдэгдэнэ” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалтын “энэ тухай дахин өргөдөл гаргах” гэснийг “давхцаагүй талбайн зургийг энэ хуулийн 17.2-т заасны дагуу гаргаж ирүүлэх” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “хугацаа дуусахаас 1 сарын өмнө” гэснийг “хугацаа дуусахаас өмнө” гэж, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “хангаагүй бол” гэснийг “хангаагүй бөгөөд энэ зүйлийн 22.1-д заасан баримт бичгийг бүрэн ирүүлээгүй бол” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.13 дахь заалтын “байгууллагад” гэснийг “байгууллага болон бүх шатны нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад” гэж, 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсгийн “35.6-д” гэснийг “35.7-д” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-19.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

6.1. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.